



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 02 сарын 04 өдөр

Дугаар 5/10

Ховд

Б.Баярсүхийг ажилд томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 22 дугаар зүйлийн 22.1 дэх заалт, Газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.8, 20.3 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газартай зөвшилцөн Авлигатай тэмцэх газрын 2019 оны 01 дүгээр сарын 15-ны өдрийн 05/369 тоот албан бичгээр урьдчилсан мэдүүлэг нь хянагдаж ирсэн аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын үүрэгт ажилд Баатаржавын Баярсүхийг 2019 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс эхлэн томилсугай.

2.Б.Баярсүхийг Монгол улсын Засгийн газрын 2019 оны 24 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан төрийн захиргааны албан тушаалын цалингийн сүлжээний ТЗ-9-3 дахь шатлалаар цалинжуулж, зэрэг дэвийн нэмэгдлийг 22 хувиар, удаан жилийн нэмэгдлийг 10 хувиар тус тус үндсэн цалингаас тооцож олгохыг тус газрын нягтлан бодогч /н.Эсбаатар/-д зөвшөөрсүгэй.

3. Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль тогтоомжийг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллахыг Б.Баярсүхэд үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax Б/10 Ch

02 00456